



89

БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/49

Номгон

Газар олгох ажлыг зохион байгуулах
ажлын хэсгийг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 8/50 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөөний дагуу гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар иргэдэд газар олгох, өргөдөл хүлээн авах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

С.Батцэрэн

(Сумын Засаг даргын Орлогч)

Гишүүд:

С.Должинсүрэн

(Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын

Газар зохион байгуулалтын төлөвлөлт, өмчлөл хариуцсан

ахлах мэргэжилтэн)

Х.Баасанжаргал

(Баянхонгор сумын газрын даамал)

Б.Нармандах

(Баянхонгор сумын газрын даамал)

Н.Пүрэвжаргал

(Хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан

мэргэжилтэн)

Ц.Баасанбат

(Газар зохион байгуулалт, инженерийн шугам сүлжээ, зам

талбай хариуцсан ажилтан)

Захирамж 2023 он

621010899

Д.Отгонтунгалаг

(Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан ажилтан)

Нарийн бичгийн дарга:

А.Цэцэнбилэг

(Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын

Газрын удирдлагын хэлтсийн дарга)

2.Өргөдлийг ирсэн дарааллын дагуу гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар олгох зарчмыг боловсруулан сумын Засаг даргаар батлуулан ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Хүрэлсүх)-д даалгасугай.

ДАРГА



Г.ЭНХБАЯР